

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2-3
2. Аудитын тайлан.....	4-7
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4-5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5-6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	8-14
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1. Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.24 № 1315
танай _____ -ны № _____ -Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Авлигатай тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний болон өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Авлигатай тэмцэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2020\0424SAG15.Docx

001030606

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red rectangular official stamp with a double border. Inside the stamp, there is a handwritten signature in black ink that reads "Д.ЗАНДАНБАТ". The stamp also contains some faint Mongolian text and a central emblem.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Авлигатай тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч З.Дашдаваа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авлигатай тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Цэрэннамжил хариуцаж хэрэгжүүлэв.

Авлигатай тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 06/3911 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Авлигатай тэмцэх газрын зорилго нь *“Авлигатай тэмцэж, шударга ёсыг тогтоон хөгжил дэвшилд хүргэх”*-д орших бөгөөд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага юм.

Авлигатай тэмцэх газрын 2019 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилтууд:

1. Бүхий л шатанд удирдлагын манлайллыг хөгжүүлж, удирдахуйн болон мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад албан хаагчдыг системтэй хамруулан чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;
2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтот цогц арга хэмжээг суурь судалгааны үндсэн дээр хэрэгжүүлэх, хүрэх үр дүнг тодорхойлон бүрэн хангаж ажиллах;
3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд багийн болон иргэдийн хяналтын зөвлөлийн гишүүдийн үүрэг оролцоог улам нэмэгдүүлж, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд мэдээллийн ил тод байдлыг бий болгон, түүнд хяналт тавих иргэдийн хяналтын тогтолцоог төлөвшүүлж бэхжүүлэх;
4. Хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн цахим системийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгож, авлига, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлж хянан шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх;
5. Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллаж, хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт, хохирол нөхөн төлөлтийг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шимтгэлийн хувь хэмжээ;
- Монгол Улсын Их хурлын 2019 оны 67 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Авлигатай тэмцэх газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолол групп” ХХК-ний “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Авлигатай тэмцэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Авлигатай тэмцэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 15,644.2 сая төгрөгөөс тооцон 156.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 1 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй, эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Авлигатай тэмцэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,580,630.7 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,221,572.2	2,159,102.1	(62,470.1)
Авлага	2,900.0	2,585.0	(315.0)
Урьдчилгаа	2,360,439.5	443,058.7	(1,917,380.8)
Бараа материал	3,008,033.4	2,749,242.4	(258,791.0)
Үндсэн хөрөнгө	13,151,399.7	16,970,987.3	3,819,587.6
Нийт хөрөнгө	20,744,344.8	22,324,975.5	1,580,630.7
Өр төлбөр	2,666,348.7	2,511,668.5	(154,680.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,077,996.2	19,813,307.0	1,735,310.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,744,344.8	22,324,975.5	1,580,630.7

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/80 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хүлээн авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”-ын дагуу хэрэг бүртгэл мөрдөн байцаах, шалгагдах шатанд байгаа хөрөнгө, барьцааны мөнгө, эд зүйлс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь АТГ-ын даргын 2019 оны А/50, А/100 дугаар тушаалаар 13.7 сая төгрөгийн цаашид ашиглагдах боломжгүй болсон зүйлсийг акталж, данс бүртгэлээс хассан болон хангамжийн материалыг албан хэрэгцээнд зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 422 дугаар тогтоолоор Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газраас 329.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсан, төсвийн хөрөнгө оруулалтаар 805.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/3248, А-5/1316 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн АТГ-ын даргын 2019 оны А/50, А/104 дүгээр тушаалаар нийт 108.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1073 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон тул 220.2 сая төгрөгийн газрыг данс бүртгэлээс тус тус хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд санхүүгийн түрээсийн гэрээгээр үүссэн урт хугацаат өр төлбөрийн үе шатны төлбөр болох 47.5 сая төгрөг болон хувь хүнд төлөх өглөг төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,735,310.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 122.5 сая төгрөгийн бичилт нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газраас 2017 онд хүлээн авсан хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 422 дугаар тогтоолоор 329.7 сая төгрөгөөр үнэлж шилжүүлснийг АТГ-ын даргын 2019 оны А/130 дугаар тушаалаар орлогод авч данс бүртгэлд тусгахдаа 2017, 2018 оны элэгдлийг нөхөн тооцож хуримтлагдсан үр дүн дансанд хаасантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Авлигатай тэмцэх газрын хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 17,124.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 16,304.4 сая төгрөгийг урсгал зардалд, 820.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 17,124.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн урсгал зардалд 16,304.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 16,184.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 16,085.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 99.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 820.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 820.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсөв: НИТХ-ын даргын 2019 оны 91 дүгээр захирамжаар Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийхэд шаардагдах 100.0 сая, үйл ажиллагааны хүрээнд бий болсон түрээсийн орлого 25.2 сая, нийт 125.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 100.0 сая төгрөгийг төлөвлөгөөний дагуу зарцуулж, 25.2 сая төгрөгийг Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж ажиллаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Авлигатай тэмцэх газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 24 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Авлигатай тэмцэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Авлигатай тэмцэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБДОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төгрөг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,592,945.1	5,353,988.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,221,572.2	2,159,102.1
33	АВЛАГА	2,900.0	2,585.0
34	УРЬДЧИЛГАА	2,360,439.5	443,058.7
35	БАРАА МАТЕРИАЛ	3,008,033.4	2,749,242.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,151,399.7	16,970,987.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,151,399.7	16,970,987.3
392	Биет хөрөнгө	10,924,239.0	14,412,398.1
393	Биет бус хөрөнгө	2,227,160.7	2,558,589.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,744,344.8	22,324,975.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,666,348.7	2,511,668.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,264,124.4	2,159,005.1
413	Өглөг	948.0	-
414	Урьдчилж орсон орлого	2,215,724.2	2,109,444.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	402,224.3	352,663.5
422	Урт хугацаат зээл	402,224.3	352,663.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,077,996.1	19,813,307.0
51	Засгийн газрын хувь оролцоо	18,077,996.1	19,813,307.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,569,468.6	3,349,266.6
512	Хуримтлагдсан үр дүн	13,143,783.8	15,099,296.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,364,743.7	1,364,743.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,744,344.8	22,324,975.5

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төгрөг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,390,250.8	17,590,611.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,601.9	461,376.2
120	Нийтлэг татварын бус орлого	309,601.9	461,376.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,080,648.9	17,129,235.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,025,872.2	15,644,158.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,025,872.2	15,644,158.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,468,739.2	15,439,396.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,377,391.5	5,454,906.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	277,511.1	355,459.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,223.4	99,668.7
2104	Хангамж, бараа материалын зардал	251,390.7	424,409.2
2105	Нормативт зардал	2,455.5	2,018.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,651.0	53,174.6
2107	Томилолт, зочны зардал	129,566.4	180,771.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,425.3	6,222,601.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,301,124.3	2,646,388.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	557,133.0	204,761.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,364,378.6	1,946,453.5
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	131,585.4
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	111,773.5	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(111,773.5)	131,585.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,252,605.1	2,078,038.9

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	/мян.төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	15,210,678.8	17,189,393.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	130,029.9	49,657.9
120	Нийтлэг татварын бус орлого	130,029.9	49,657.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,080,648.9	17,139,735.6
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	12,335,507.9	13,714,810.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,335,507.9	13,714,810.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,734,724.9	13,393,268.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,375,077.2	5,454,647.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	277,511.1	355,459.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,342.9	108,017.1
2104	Хангамж, бараа материалын зардал	228,334.1	238,616.9
2105	Нормативт зардал	-	49,670.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,694.4	51,690.1
2107	Томилолт, зочны зардал	152,434.1	185,014.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,133,998.4	6,216,447.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	430,332.7	733,705.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,783.0	321,541.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,875,170.9	3,474,583.5
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	135,800.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,789,793.0	3,672,853.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,789,793.0	3,672,853.5
2200	Дотоод эх үүсвэрээр	2,789,793.0	3,672,853.5
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,789,793.0)	(3,537,053.5)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,377.9	(62,470.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,136,194.3	2,221,572.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,221,572.2	2,159,102.1

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төгрөг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
С01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,377,790.9	0.00	11,377,790.9
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,115.4	0.00	3,115.4
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,380,906.3	0.00	11,380,906.3
С04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	1,364,743.7	0.00	1,364,743.7
С05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	2,079,741.0	0.00	2,079,741.0
С07	Тайлант үеийн үр дүн	3,252,605.1	0.00	3,252,605.1
Д01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,077,996.1	0.00	18,077,996.1
Д02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-122,526.0	0.00	(122,526.0)
Д03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,955,470.2	0.00	17,955,470.2
Д05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-220,202.0	0.00	(220,202.0)
Д08	Тайлант үеийн үр дүн	2,078,038.9	0.00	2,078,038.9
Д09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,813,307.0	0.00	19,813,307.0

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,221,572.2	-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,124,415.9	16,905,028.6	219,387.3	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,304,415.9	16,085,028.6	219,387.3	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,197,860.3	15,979,274.1	218,586.2	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,454,647.6	5,454,647.6	-	100.0
210101	Үндсэн цалин	3,297,793.6	3,329,644.5	(31,850.9)	100.9
210102	Нэмэгдэл	1,983,458.8	1,983,458.8	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	173,395.2	141,544.3	31,850.9	81.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	357,680.5	355,459.6	2,220.9	99.4
210201	Тэтгэврийн даатгал	208,383.2	200,211.1	8,172.1	96.1
210202	Тэтгэмжийн даатгал	25,092.9	23,554.2	1,538.3	93.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,092.9	18,702.6	6,390.3	74.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,018.6	4,644.8	373.8	92.5
210205	Эрүүл мэндийн даатгал	94,092.9	108,346.9	(14,254.0)	115.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,017.1	108,017.1	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	56,263.8	62,176.6	(5,912.8)	110.5
210302	Түлш, халаалт	46,305.3	39,099.1	7,206.2	84.4
210303	Цэвэр, бохир ус	5,448.0	6,741.4	(1,293.4)	123.7
2104	Хангамж, бараа материалын зардал	240,399.3	240,399.3	-	100.0
210401	Бичиг хэрэг	60,294.0	59,798.2	495.8	99.2
210402	Тээвэр, шатахуун	81,026.8	55,776.0	25,250.8	68.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,601.7	66,226.2	(3,624.5)	105.8
210404	Ном, хэвлэл	4,000.0	1,751.0	2,249.0	43.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,380.0	1,656.0	724.0	69.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,096.8	55,191.9	(25,095.1)	183.4
2105	Нормативт зардал	49,670.3	49,670.3	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,670.3	49,670.3	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,716.9	85,716.9	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,418.3	31,066.9	-	109.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	806.4	175.2	-	21.7
210604	Урсгал засвар	56,492.2	54,474.8	2,017.4	96.4
2107	Томилолт, зочны зардал	186,316.3	185,014.1	1,302.2	99.3
210701	Гадаад албан томилолт	40,000.0	38,704.9	1,295.1	96.8
210702	Дотоод албан томилолт	137,316.3	137,316.3	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,000.0	8,992.9	7.1	99.9

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,886,405.4	8,881,285.8	5,119.6	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,699,179.7	8,694,128.5	5,051.2	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	21,850.6	21,815.6	35.0	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,694.0	2,660.6	33.2	98.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	594.0	594.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,800.0	150,800.0	-	100.0
210807	Газрын төлбөр	11,287.1	11,287.1	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	829,006.9	619,063.4	209,943.5	74.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,986.0	57,426.5	-	61.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	736,020.9	561,636.9	174,384.0	76.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,555.6	105,754.5	801.1	99.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	45,155.6	44,354.5	801.1	98.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	45,155.6	44,354.5	801.1	98.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,400.0	61,400.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,800.0	42,800.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,600.0	18,600.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	820,000.0	820,000.0	-	100.0
222001	Тоног төхөөрөмж	820,000.0	820,000.0	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,124,415.9	16,905,028.6	219,387.3	98.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,124,415.9	16,905,028.6	219,387.3	98.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	17,124,415.9	16,905,028.6	219,387.3	98.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,159,102.1	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	172	172	-	100.0
620001	Удирдах ажилтан	13	13	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	146	146	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13	13	-	100.0

3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		125,200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		125,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		125,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	125,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		125,200.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	125,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		125,200.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		125,200.0

